



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,  
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060  
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,  
Цахим шуудан: info@energy.gov.mn

2024.04.11 № В/1063

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулгад хариу хүргүүлэх тухай**

Эрчим хүчний яамнаас зарласан ЭХЯ/20240101009 дугаартай, Улсын төсвөөр хэрэгжих Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Хэнтий, Хэрлэн сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохын сонирхогч компаниас ирүүлсэн асуултын дагуу дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Асуулт: Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.3-д “ТЗ-2.1: 0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ болон түүнээс дээш ангилалтай тусгай зөвшөөрөлтэй байна” гэж заасан байна. Гэтэл ажлын зураг, тоо хэмжээтэй танилцахад 110/35/6кВ-ын Өндөрхаан дэд станцын өргөтгөлийн ажлын хүрээнд 35кВ-ын ИХБ-ийг буулгах, шинээр зөөж барих ажлууд багтсан байна. Иймд “0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ” тусгай зөвшөөрөл нь энэхүү ажлыг гүйцэтгэх шаардлагыг хангах эсэх талаар тодруулж өгнө үү.

Хариулт: 110/35/6кВ-ын Өндөрхаан дэд станцын өргөтгөлийн ажлын хүрээнд 35кВ-ын хүчдэлийн түвшинд ажиллах тоноглол багтаж байгаа тул тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт (ТШЗ 19.3-д)-д Багц-1-д тусгагдсан ажлыг Эрчим хүчний яамны ТЗ-2.2: 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ болон түүнээс дээш ангилалтай тусгай зөвшөөрөлтэй гүйцэтгэнэ.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Н.ТАВИНБЭХ

170600000962